



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/737

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 11/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Огторгуйн асар Нийтийн мэдээллийн төв" НҮТББ буюу "Ховд телевиз" Юнивишн ХХК-тай телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулж иргэд хэрэглэгчдэд хүргэхээр байгуулсан гэрээг үндэслэн "Телевизийн нэвтрүүлэг дамжуулсаны түрээсийн төлбөр"-т дэмжлэг үзүүлсүгэй.

2. "Телевизийн нэвтрүүлэг дамжуулсаны түрээсийн төлбөр"-т дэмжлэг болгон олгох 3 000 000 төгрөг /гурван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 11/ 02 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан Хөшөөт хөгжил сангийн "2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ"-ний 5.8 дахь заалтад тусгасан Юнивишн, Ddish дахин дамжуулах сүлжээнд орон нутгийн телевизийг холбох зардлаас гаргасугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг холбогдох баримт, бичгийн дагуу тооцон шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /М.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн телевизийн нэвтрүүлгийн дахин дамжуулалт, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн ажилтан /Х.Алтантуяа/-д үүрэг болгосугай


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/737-Bo

Аймгийн Засаг даргын 2020 оны
11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/737 дугаар захирамжийн хавсралт



ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛЭГ ДАМЖУУЛСАНЫ ЗАРДАЛ

№	Байгууллагын нэр	Дэмжлэг үзүүлэх эх үүсвэр	Санхүүжилтийн хэмжээ /төгрөг/
1	Огторгуйн асар Нийтийн мэдээллийн төв НҮТББ	“2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ”-ний зардал	3 000 000
Дүн			3 000 000

-оОо-